

## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....	13
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	16
7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	17
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	18
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	22
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах.....	24

### Зургийн жагсаалт

Зураг 1. Нүүрс ачиж буулгах талбай.....	3
Зураг 2. Технологийн процесс.....	3
Зураг 3. Оффис, ажилчдын байр.....	4
Зураг 4. Оффис, ажилчдын байрны дотоод байдал.....	4
Зураг 5. Техник, тоног төхөөрөмж.....	5
Зураг 6. Судалгааны талбайн байршил.....	6

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт.....	8
Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим.....	10
Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал.....	25

## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Ёл ресурс” ХХК нь уурхайнуудаас нүүрс худалдан авч, нөөцлөн, шилжүүлэн ачиж экспортлох зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт Цагаан хаданд нийт 10 га талбайд 2012 оноос Гаалийн хяналтын талбай байгуулж, үйл ажиллагаа явуулж байна.

### **Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Альфа буйлдингийн оффис, 2 давхар, 201 тоот. Ёл групп

Утас: 99111811, 86888585, 89284040

“Гаалийн хяналтын талбай” нь нийт 10 га талбайтай.


- Нүүрс ачих буулгах талбай
- Ажилчдын суурин, оффисын байр

### **Нүүрс ачиж буулгах талбай**

Эзэмшил талбай 300000 тн ачаа хүлээн авах хүчин чадалтай бөгөөд хоногт 100-150 автомашин хүлээж авах боломжтой. Өдөрт 500 орчим, сард 65000 тн нүүрс буулгаж, мөн тэр хэмжээний нүүрсийг ачиж, Гашуун сухайтын боомтоор нэвтрүүлнэ.



Зураг 1. Нүүрс ачиж буулгах талбай



Зураг 2. Технологийн процесс

## Барилга байгууламж

Гаалийн хяналтын талбайд стандартын дагуу шинэ шатанд гаргах ажлын хүрээнд ажилтан, хамтран ажиллагчдын амьдрах орчин ая тухтай байдлыг өндөр түвшинд тавьж, орчин үеийн сантехник цэвэр бохирын асуудлыг шийдсэн боловсон 00, халуун ус, зоогийн газар, оффис, өрөөнүүд гэх мэт байрыг барьж тохижуулсан.

- Гал тогоо, хоолны зал, амрах өрөө бүхий ажилчдын байр – 108.9 м<sup>2</sup> (33м х 3.3м)
- Гаалийн хяналтын байр болон пүүний байшин – 27 м<sup>2</sup> (3м х 9м)
- Засварын газар 20 м<sup>2</sup> (4м х 5м)
- Барааны агуулах 20 м<sup>2</sup> (4м х 5м)
- Харуулын байр зэрэг барилга байгууламжууд



Зураг 3. Оффис, ажилчдын байр



Зураг 4. Оффис, ажилчдын байрны дотоод байдал

## ТЕХНИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

- Ковш – 2ш
- Аж ахуйн машин – 2ш
- Цахилгааны мотор – 1ш
- Хяналтын жин - 200 тн-ын даацтай




*Зураг 5. Техник, тоног төхөөрөмж*

## 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

“Гаалийн хяналтын талбай” нь Өмнөговь аймгийн Ханбогд сум нутаг дэвсгэр Цагаан хад хэмээх газарт сумын төвөөс зүүн урагш 70км, Гашуун Сухайтын хилийн боомтоос 23 км-т байрлана.

“Ёл ресурс” ХХК нь тус сумын засаг даргын 2018 оны 02 сарын 05-ний өдрийн А/34 дугаар захирамжийг үндэслэн 4601008730 тоот нэгж талбар бүхий 10 га газрыг 15 жилийн хугацаатай эзэмших эрх авсан байна.



Зураг 6. Судалгааны талбайн байршил

### Усан хангамж

Хэрэглээний усаа талбайгаас 2км зайд байрлах өрөмдмөл гүний худгаас авдаг. 10 тн-ын машинаар тээвэрлэдэг.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Аливаа төслийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг зөв оновчтой тогтоох нь байгальд ихээхэн хэмжээний хохирол учруулан, эвдрэл доройтолд орохоос сэргийлэн улмаар хүрээлэн буй орчныг хамгаалах чухал арга хэмжээ юм.

Төсөл хэрэгжих талбай нь Монгол улсын хилийн бүсэд нутагт байрлах тул нүүрс ачиж буулгах бүхий л үе шатанд тоос шороо дэгдэхээс хамгаалах, олон салаа зам гаргах зэргээр хөрсний эвдрэлийг ихэсгэхгүй байх шаардлагатай болно.

Монгол орны нөхцөлд гаалийн хяналтын бүсийн хувьд онц аюултай хүчтэй салхи, уруйн үер (хүчтэй аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай бөгөөд энэ тухай энэ тайланд тодорхой дурдсан болно.

Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой асуудал

Төслийн үйл ажиллагаа дараалал, барилга байгууламжийн өнөөгийн шийдлийг 2 дугаар бүлэгт авч үзсэн. Талбайд нүүрс буулгах, ачихтай холбоотой үүсч буй тоосжилтыг бууруулах, усан хангамжийн шийдэл, төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчин болон нийгмийн хамгааллын арга хэмжээний асуудлыг тодорхой болгосон төлөвлөлтүүдийг зайлшгүй хийх шаардлагатай байгаа нь тогтоогдсон тул зардлыг нарийвчлан тооцож, энэ ажлыг чухам хэн хариуцаж, хэзээ гүйцэтгэх зэргийг тодорхой болгох шаардлага зайлшгүй гарч байгаа.

Барилга байгууламж барих болон үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудал

Гаалийн хяналтын талбай нь жилийн турш зогсолтгүй үйл ажиллагаа явуулах бөгөөд цаашдаа төслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилго тавьж байна. Нүүрс тээвэрлэлт байнга хийгдэнэ. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад элэгдэж эвдрэлд орсон талбайн тохижилт, техникийн нөлөөллөөс хамгаалсан хатуу хучилт, салхины хаалт зэргийг хийж тоосжилт бууруулах нөхцөлийг хангах нь зүйтэй юм.

Түлш шатахуун, шатах тослох материалыг ашиглах явцад осол аваараас сэргийлэх, аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлаж байх шаардлагатай болно. Мөн хог хаягдлын ангилсан стандартын шаардлага хангасан цэг байгуулах, бохир усыг дахин ашиглах, ариутгах, цэвэрлэх зэрэг ажлыг судалж нэвтрүүлэн үлгэр жишээ байх хэрэгтэй. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг мөрдөж ажиллах шаардлагатай.

## Төслийг хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал

Төслийн үйл ажиллагааны үед байгаль хамгаалах ажлыг бодитойгоор төлөвлөх, өөрөөр хэлбэл санхүүгийн болон хариуцлагын тогтолцооны түвшинд гол анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед уг талбайн байршил, төслийн техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлах жагсаалтанд түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Хүснэгт 1. Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөллийн үр дагавар			
		Нөлөөлөхгүй	Бага	Дунд	Их
<b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>					
1.	Голын гольдролыг эвдэж, өөрчлөх	х			
2.	Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
3.	Үерийн аюулд өртөх		х		
4.	Түүх, соёлын дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх	х			
5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	х			
6	Булаг шандын усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	х			
<b>2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал</b>					
7	Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, түүхий эдийг ачиж буулгах, хадгалах болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой		х		
8	Осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			х	
9	Үйл ажиллагааны үеийн үерийн хамгаалалтын асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой			х	
10	Төсөл хэрэгжүүлэх үед хорт бодис, нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан, үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой	х			
11	Ус хэрэглэх, усны чанарыг хамгаалах, хянах асуудал			х	
12	Ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон дуу чимээ гарах			х	
13	Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх				х
14	Төслийн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
<b>3. Барилга байгууламж барих, засахтай холбогдож гарах байгаль орчны асуудал</b>					



15	Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	x			
16	Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл			x	
17	Үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл			x	
<b>4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал</b>					
18	Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хир зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				x
19	Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх			x	
20	Хөрсний эвдрэл элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)		x		
21	Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх	x			
22	Газар ашиглалтад хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтад гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх		x		
23	Шуурхай хяналтын асуудал (төсөлд шуурхай хяналтын хугацаа, мөнгө зардал тусгагдсан эсэх)		x		
24	Төслийн талбайг өөр зориулалтаар ашиглах боломжийг авч үзсэн эсэх	x			
25	Төслийг хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал				x
<b>5. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)</b>					
26	Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах	x			
27	Төслийн техник технологийн шийдлийг техник, эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал		x		
<b>Нөлөөллийн үнэлгээний тоон утгын хувь</b>		<b>37%</b>	<b>26%</b>	<b>26%</b>	<b>11%</b>

Төслийн байршил, техник технологийн шийдэл болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд үзүүлэх болзошгүй нөлөөллийн дүнгээс үзэхэд 37.0 хувь нь нөлөөлөлгүй, 26 хувь нь бага, 26 хувь нь дунд, 11 хувь нь их нөлөөлөл үзүүлэхээр байна.

Гаалийн хяналтын талбайд нүүрс ачиж буулгах явцад үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим, мөн уг нөлөөллөөс байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэхийг тодруулах) болзошгүй нөлөөллийн үнэлгээг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

Нөлөөллийн төрөл	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Гадаргын усны урсцын өөрчлөлт										
Гадаргын усны чанарын өөрчлөлт										
Ургамлын бүтцийн өөрчлөлт		x			x		x			x
Хөрсний элэгдэл, эвдрэл		x			x		x			x
Геологийн тогтцын өөрчлөлт										
Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт		x	x	x				x		
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x	x	x				x		
<b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээр, тэжээлийн байдал			x					x		
Эрдэс түүхий эдийн нөөц										
Эрчим хүчний нөөц		x			x	x				x
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>										
Ундны усны чанар, хэмжээ										
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x			x					x	
Хөрсний бохирдол		x			x		x	x		
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх										
Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x						x
<b>4. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+			+
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+		+			+			+
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх		+			+		+			+
Хүн амын тоо өөрчлөгдөх	+			+			+			+
<b>5. Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x	x		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
Тусгай хамгаалалтай ба цогцолбор газарт нөлөөлөх		x	x		x		x	x		
Түүх соёлын дурсгал зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
<b>6. Эдийн засаг, байгаль орчин</b>										
Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+				+		+			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+	+		
Ажлын байр нэмэгдэх	+			+			+			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		+			+		+			+
<b>7. Бусад нөлөөлөл</b>										
Шороон зам харилцаа машин										

механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх	x				x		x	x		
Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтын усыг бохирдуулах	x				x		x	x		
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих	x			x		x	x	x		
<b>ДҮН</b>	<b>13</b>	<b>10</b>	<b>4</b>	<b>8</b>	<b>15</b>	<b>4</b>	<b>16</b>	<b>13</b>	<b>11</b>	

Эдгээр болзошгүй нөлөөллийг хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмээр нь тодруулбал:

Дээрх хүснэгтээс үзэхэд гаалийн хяналтын талбай цаашид үйл ажиллагаа явуулахад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл 11, бусад сөрөг нөлөөлөл 3 буюу бүгд сөрөг нөлөөлөл 14, нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөлөл 10 болж нийт 24 нөлөөлөл болж байна. Үүнээс:

**Шууд нөлөөлөл.** Байгаль орчин, экологид үзүүлэх болзошгүй нөлөөллийн 4 нь шууд нөлөөлөлд хамаарахаар байна. Эдгээрт нүүрсийг ачиж буулгахаас үүсэх тоос, машин техникийн дуу чимээ, үүнтэй уялдан хэсэг газрын ландшафт өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл байна. Түүнчлэн зам тээврийн харилцаанаас үүсэх хэсэг газрын хөрс эвдрэх, хөрсний элэгдэл үүсэх, ургамлын бүтэц өөрчлөгдөх, ахуйн бохир ус, хог хаягдлын цэгийн ариутгалыг муу хийснээс орчин бохирдох нөхцөлийг бүрдүүлж байна.

**Шууд бус нөлөөлөл.** Барилга байгууламж барихад өртсөн газар болон нүүрс ачиж буулгах хэсэгт хөрс эвдрэх, бохирдох, уур амьсгалын бичил өөрчлөлт гарах, дуу чимээнээс зэрлэг ан амьтад дайжих, санамсар болгоомжгүйгээс хээрийн болон тухайн газарт түймэр гарах зэрэг нөлөөлөл байж болно. Түүнчлэн тусгай хамгаалалтай газар нүүрсний ачилтын үед гарсан тоосонцор салхиар тээгдэн хөрсийг бүрхэх замаар тухайн хэсгийн хөрс ургамалд нөлөөлж болзошгүй. Эндээс 4 нөлөөлөл нь эерэг, 6 нөлөөлөл сөрөг нийт 10 нөлөөллийг үзүүлж болно.

**Богино хугацааны нөлөөлөл.** Цаг агаарын хуурай үед машин механизмын үйл ажиллагааны дүнд их хэмжээний тоос агаарт гарах, салхитай үед нүүрс ачилтаас тоос хийсэх, хүнд механизмын хөдөлгүүрийн дотоод шаталт, дизель станцыг ажиллуулахад ялгарах нефть бүтээгдэхүүний хорт хий, утаа зэргээс агаар богино хугацаанд бохирдоно. Түүнчлэн хүнд механизмын дуу чимээ болон ачилтын үе дэх тоног төхөөрөмжийн дуу чимээ агаарт тархана. Дуу чимээ тооноос амьтад зайлна. Агаарт тархсан нүүрсний тоос агаарыг богино хугацаанд түр бохирдуулж, ажиллагсдын эрүүл мэндэд муугаар нөлөөлөх, ойр орчмын хөрс, ургамал, бэлчээрийн талбай тоосонд дарагдаж өөрийн унаган төрхөө алдах, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, ялаа шавьж үржихэд хүрч болох нь мөн богино хугацааны нөлөөлөлд хамаарна. Иймд салхи ихтэй үед утаа ба тоос

шорооны бохирдлыг багасгах зорилгоор дизель хөдөлгүүрийн утааны янданд шүүлтүүр тавих, ухагдсан хөрс шороо, машин механизмд талхлагдсан орчны газрыг ялангуяа авто замыг шаардлагатай үед усалж, чийглэж байх зэрэг нэмэлт арга хэмжээг авч байх нь зүйтэй. Хог хаягдлын цэгийг графикийн дагуу ариутгаж байх хэрэгтэй. Нийт богино хугацааны нөлөөлөл 8 байгаагаас эерэг-4, сөрөг-4 байна.

**Урт хугацааны нөлөөлөл.** Хүснэгтээс үзэхэд нүүрс ачиж буулгах үед байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн ихэнх нь буюу 15 нь удаан хугацаагаар буцалтгүй нөлөөлөл үзүүлэхээр байна. Үүнд ургамлын бүтцийн өөрчлөлт, хөрсний элэгдэл, эвдрэл, хөрсний бохирдол зэрэг сөрөг нөлөөллөөс гадна дэд бүтцийн хөгжил, цахилгаан эрчим хүчээр хангагдах, хүн амын болон нутгийн орлого нэмэгдэх зэрэгт буцалтгүй эерэгээр нөлөөлөхөөр (7 нөлөөлөл) харагдаж байна.

**Буцаж нөлөөлөх нөлөөлөл.** Энэхүү нөлөөлөлд ахуйн хог хаягдлын ариутгалыг хийгээгүйгээс хүн амын эрүүл мэндэд эргэж муугаар нөлөөлөх, мөн амьтанд нөлөөлөх магадлалтай байна гэж үздэг. Тухайн үйл ажиллагааны хувьд цацраг идэвхт бодис ашиглахгүй. Гэвч экспортлож буй нүүрсний цацраг идэвхт байдлыг шинжлүүлэн тодорхойлоход цаашид анхаарах хэрэгтэй. Хорт хийн хувьд машин техникийн утаа агаарын хольцноос өөр богино хугацаанд үзүүлэх нөлөөлөл байхгүй болно. Нүүрсний агуулахад удаан хугацаагаар их хэмжээгээр нүүрс хадгалагдахад хүрвэл нүүрсний өөрөө шаталтаас сэргийлэх арга хэмжээг авсан байвал зохино. Энэ талаар байгаль орчны жилийн төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй. Энэ тээвэрлэлтийн систем ажиллах хугацаанд хүн амын тоо нэмэгдэж, үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлнө. Нийт нөлөөллийн тоо 4-өөс эерэг-3, сөрөг-1 хүчин зүйл байна.

**Нөлөөллийн эрч, хүч.** Болзошгүй нөлөөллийн ихэнх нь бага-13, үүнээс эерэг-2, сөрөг-11, дунд -11 үүнээс эерэг-8, сөрөг-3, хүчтэй -0 зэрэгт хамаарч нийт 24 нөлөөллийн 14 нь сөрөг буюу 58.30%, 10 нь эерэг буюу 41.70%-ийг эзэлж байна. Иймээс нөхөн сэргээх асуудалд тоосноос хамгаалах ажил ялангуяа салхины хүчийг сааруулах зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна. Ялангуяа энэ нь нүүрс агуулах талбайн ачих буулгах талбайд хамаарагдаж байна.

Иймээс байгаль байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төслийн ажлын онцлогтой холбож боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.

#### 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь гаалийн хяналтын талбай байршиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсч буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм. Тиймээс төслийн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитойгоор төлөвлөсөн БОМТ-г төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлөө бүрдүүлэх нь энэхүү төлөвлөгөөний үндсэн зорилго болно.

БОМТ үндсэн зорилгоо хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхийн хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдуулах;
- БОМТ-ний хэрэгжилтийг компанийн удирдлага өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр гаалийн хяналтын талбайг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно.
- БОМТ-г боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаа нь БОАЖСайдын 2019 оны 10 сарын 29-ны өдөр баталсан А/618 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтална.
- Монгол Улсын “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9-р зүйлийн 8-р заалт: “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.

### 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Хорт хийн ялгарлаас агаарын бохирдол үүсэх	Үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтад тогтмол оруулж, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх	Машин техникүүд	ш	Дотоод төлөвлөлтөөр			2-р улирал	- Байгаль хамгаалах тухай хууль - Агаарын тухай хууль, - MNS 4585:2016
2.		Тоосжилтыг бууруулах зорилгоор хуурайшилттай үед зам талбайг усалж байх	Талбайн хэмжээнд	удаа	Дотоод төлөвлөлтөөр			Хуурай-шилттай үед	- Зөрчлийн тухай хуулийн 6.1-ийн 2
3.	Тоосжилт	Гаалийн хяналтын талбайн автомашины зогсоол хэсгийг хайрган хучилттай болгох. Нийт 10 га талбайгаас 2024 онд 0.3 га талбайг хайрган хучилттай болгоно.	0.3	га	1100	-	3300.0	2-р улирал	- Агаарын тухай хууль - Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
4.	Хөрсний элэгдэл, эвдрэл	Гаалийн хяналтын талбайн орц, гарц хэсгийг цементлэн хатуу хучилттай болгох	100	м <sup>2</sup>			500.0	2-3-р улирал	
5.	Хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх	Талбай болон ойр орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээг сайжруулж, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Төслийн талбай	ш	30.0	5	150.0	2-р улирал	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
6.		Засварын газар, хог хаягдлын цэгийн доорх талбайг хатуу хучилттай болгох	-	м <sup>2</sup>	-	0.01	150.0	Ажил эхлэхээс өмнө	
7.	Хөрс бохирдох	Стандартын шаардлага хангасан нүхэн жорлон, бохирын цооног байгуулах	Зургийг хавсаргав	1ш	500.0			2-3 улирал	- Хог хаягдлын тухай хууль - MNS 5924:2015
8.	Хөрс,	Дахин ашиглахгүй нөлөөлөлд	Тухайн		Дотоод зохион байгуулалтаар			Тухай бүр нь	- MNS 5918:2023

	ургамал талхлагдах	өртсөн талбайн хөрсийг сийрүүлэн шимт хөрсөөр 5 см хүртэл зузаантай хучилт хийж ургамалжуулах, нөхөн сэргээх	тохиолдолд				
<b>Осол, эрсдэлээс сэргийлэх төлөвлөгөө</b>							
9.	Осол аваар гарах	Анхан шатны түргэн тусламжийн хэрэгслийг шаардлагатай газруудад бэлэн байлгах	5ш	-	-	Үйл ажиллагаа эхлэхэд	
10.	Галын аюул	Гал унтраах хэрэгслийг бэлэн байлгах, гал түймэр гарсан үед гарах аврах гарцын зураг, бүдүүвч схем байрлуулах	-	-	-	Тогтмол	
11.	Байгаль орчинд сөргөөр нөлөөлөх	- Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх, гал гарсан үед авах арга хэмжээний талаар сургалтыг бүх ажилчдад хийх - Шаардлагатай газруудад анхааруулах хуудас, самбар байршуулах	2 удаа	-	200.0	Улирал бүр	- Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль - Галын аюулгүй байдлын тухай хууль
12.	Гэнэтийн осол, гэмтэл	Машин, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	-	-	-	Тогтмол	
13.	Гэнэтийн осол, гэмтэл	Ажилд гарахын өмнө бүх ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр бүрэн хангах	-	-	-	Ээлжинд гарахын өмнө	
14.	Гал гарах, тэсэрч дэлбэрэх	Шатахуун түгээх хэсэг болон нөөцлүүрийн ойролцоо тамхи татах, гал гаргахыг хориглох, анхааруулах тэмдэг тэмдэглэгээ наах	3 ш	-	-	Тогтмол	
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>			<b>4800.0</b>				

## 6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 мод тарих үүрэг хүлээсэн.	Жигд /3 нас/ Сухай /Знас/ Хайлаас/Знас/ Хармаг тарих	Төслийн талбайд	ш	200	3000.0	600,0	5, 10 сард	- Газрын тухай хууль - Хөрс хамгалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
2.	Мөн төслийн талбайд мод бут тарьж хамгаалах	Суулгац тарих	Төслийн талбай	ш	300	3000.0	900,0	5, 10 сард	- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
3.	Мод бутны арчлалт хамгаалалт	Ургаагүй мод бутыг нөхөн тарих арчлалт хамгаалалт хийх	Төслийн талбай	удаа	1	200.0	200.0	Намар	
<b>Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг</b>						<b>1700.0</b>			



## 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

## 8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Үйл ажиллагаанаас ялгарах хог хаягдал, түүний ангилан ялгалт гэх мэт хог хаягдлын менежментийг тус төслийн БОННУ-д дэлгэрэнгүй тусгасан байна.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ангилах	Ажилчдын байр, оффист ангилал бүхий хогийн сав байрлуулж, хогийг ангилан ялгаж хэвшүүлэх	Төслийн үйл ажиллагаа	ш	50,000	3	150,0	2-р улирал	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”  “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
2.	Түр хадгалах	Хог хаягдал түр хадгалах цэгийн доорх талбайг нэвчилт шүүрэлт явагдахгүй, ирмэг хөвөө бүхий хатуу хучилттай болгох	Талбайн хэмжээнд	ш	80,000	1	80.0	2-р улирал	
3.	Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэгүүд, нүхэн жорлонд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэг	Удаа	10,000	7 хон бүр	120.0	Тогтмол	
4.	Дахин боловсруулах	Шил, лааз, хуванцар сав, төмөр, мод, цаас, гялгар уут гэх мэт дахин боловсруулах, ашиглах боломжтой хог хаягдлуудыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	Төслөөс үүсэх	удаа	20,000	Сард 2 удаа	240.0	сар бүр	
5.	Ахуйн хатуу хог хаягдал	Энгийн хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар устгуулах	Төслөөс үүсэх	-	Гэрээний дагуу		14 хоног тутамд		

6.	Аюултай хог хаягдал	Хаягдал батерейг хуримтлуулан “Цэнгэг усны төв”-д өгөх	Бүх хаягдал батерей	ш	-	-	-	Жилд 2 удаа
7.	Шингэн хог хаягдал	Битүүмжлэгдсэн доторлогоотой бохирын цооног байгуулж бохирыг мэргэжлийн байгууллагаар соруулах	Ахуйн шингэн хаягдал	удаа	Гэрээний дагуу			Бохирын цооногийн 70% дүүрмэгц
<b>Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал, мян.төг</b>							<b>590.0</b>	

## 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
<b>1. АГААРЫН ЧАНАР</b>								
1	Агаарын чанарын (NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> , CO, PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> ), цацраг идэвх	<ul style="list-style-type: none"> <li>- Нүүрс буулгах талбай</li> <li>- Ажилчдын байрны дотоод орчинд</li> </ul>	Жилд 2 удаа	2	36.0	144.0	Нэг удаагийн хэмжилтээр 2 ажиглалтыг нэг мөр хийнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- MNS 4585:2016</li> <li>- MNS 4048:1988</li> <li>- MNS 5002:2000</li> <li>- MNS ISO 226:2003</li> <li>- MNS 5919:2008</li> </ul>
2	Дуу шуугиан, чичиргээний хэмжилт хийх		Жилд 2 удаа	2				
<b>2. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ</b>								
1	Хөрсний агрохими, механик бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>- Ногоон байгууламж бүхий талбай</li> <li>- Нүүрс ачиж буулгах талбай</li> </ul>	Жилд 2 удаа	2	20.0	80.0	БОХЗТЛаб	MNS 3297:2019 MNS 5850:2019 бохирдуулагч элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”,
2	Хөрсний бохирдлын шинжилгээ /11 элемент/			<ul style="list-style-type: none"> <li>- Хогийн цэгийн орчим</li> <li>- Нүүрс ачиж буулгах талбай</li> <li>- Нүхэн жорлонгийн ойролцоо (эрүүл ахуй)</li> </ul>	3	25.0		
<b>3. УСНЫ ЧАНАР</b>								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	Хэрэглээний усаа зөөврөөр хангадаг худаг	Жилд 2 удаа	2	46.0	92.0	БОХЗТЛаб	MNS 4586:98 MNS 0900:2018 MNS 6148:2010

2	Усны бохирдлын хяналт хийх		Жилд 1 удаа	1	78.0	78.0		
3	Бактериологи		Жилд 1 удаа	1	45.0	45.0		
<b>4. УРГАМЛАН НӨМРӨГ</b>								
	Ургамлын зүйлийн бүрдэл, ургалт, биомасс, өндөр, г.м	Эзэмшил талбай болон нөлөөллийн бүсэд, мод тарьсан талбай	Жилд 2 удаа	-	-	-	Ургамал судлаач	Байгалийн ургамлын тухай хууль Ургамал хамгааллын тухай хууль
<b>Нийт, мян.төг</b>								<b>649.0</b>

### 10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж БОАЖЯ-аар батлуулах	-	1 улирал	Захирал	БОНБУ-ий тухай хууль, БОАЖС-ын А/618 тушаал
2.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг Өмнөговь аймгийн БОГ-т тайлагнах		11 сарын 1	Захирал, БО-ы мэргэжилтэн	БОНБУ-ий тухай хууль
3.	Нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгаас тавьсан хүсэлтүүдийг харилцан тохиролцож шийдвэрлэж ажиллах. Үүнд: - “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, газрын гэрээнд заагдсан эзэмшил газрын 10%-аас багагүй талбайд ногоон байгууламж байгуулах заалтыг хэрэгжүүлэх - БО-ыг хамгаалах тэмдэглэлт өдрүүдийг сумын ЗДТГ-тай хамтран иргэд, нөхөрлөл, байгаль хамгаалах клубуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор зохион байгуулах /Байгаль хамгаалах хавар, намрын сарын аян, Цөлжилттэй тэмцэх өдөр, Дэлхийн усны өдөр, Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр, Биологийн олон янз байдлыг хамгаалах өдөр г.м/ - Биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын хүрээнд зэрлэг амьтдад зориулан биотехникийн арга хэмжээ авах, уст цэгийг бий	Дотоод төлөвлөлтөөр	Тогтмол	Захирал	Нийгмийн хариуцлагын хүрээн

	болгож, хяналт мониторинг хийх, камер суурилуулах - Усны эрхзүйн орчныг хангаж ажиллах. Одоо ашиглаж байгаа уст цэг дээр дүгнэлт гаргуулж орон нутагтай гэрээ байгуулж төлбөр төлөх, зөвшөөрөлтэй, дүгнэлттэй уст цэгээс унд, ахуйн усаа гэрээгээр ашиглах				
	Нийт зардал, мян.төг	-			

**11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацаа	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
1	БОМТ-ий биелэлтийн тайланг Өмнөговь аймгийн БО-аар дүгнүүлэх	3% хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11-12 сар	50.0	Захирал, менежер	Аймгийн БОГ
2	Төслийн талбайн ойролцоох иргэд болон төсөл хэрэгжиж буй баг, сонирхогч талууд, засаг захиргааны ажилчид	Цаасан болон presentation хэлбэрээр тайлагнах, хэлэлцэх	Үйл ажиллагааны талаарх мэдээлэл, төслөөс БО болон нийгэм эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах багасгах чиглэлээр хийсэн ажлын тухай	10 сард	50.0	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн	Багийн хурал
3	Нийт зардал, мян.төг				100.0		



Хүснэгт 3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал, мян.төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	4800.0
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1700.0
Түүх соёлын өвийг хамгаалах	-
Хог хаягдлын менежментийг зохион байгуулах	590.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	649.0
Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	-
БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	100.0
<b>Нийт зардал</b>	<b>7839.0</b>

Өмнөговь аймгийн Ханбогд суманд орших “Гаалийн хяналтын талбай” төслийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **7839.0** мян.төг байна.

Хавсралт



Орц, гарц хэсгийн одоогийн харагдах байдал



Одоогийн бие засах газрын зураг